



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/20.

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3, 3.2.6 дахь заалт, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 3.4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:


1. Хотын аяллын хөтөч, тайлбарлагч нарт зориулсан “Япон хэлний хөтөч тайлбарлагчдын ур чадварыг дээшлүүлэх” сургалтын удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сургалтын төсөв болох 335,000 /гурван зуун гучин таван мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалт, семинарыг удирдамжид заасан хугацаанд зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг мэргэжлийн сургалт хариуцсан мэргэжилтэн /Ш.Ундармаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2017 оны 04 сарын 03-ний өдрийн
А/20 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



**“ЯПОН ХЭЛНИЙ ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧДЫН
УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ”
СУРГАЛТЫН УДИРДАМЖ**

Зорилго: Япон жуулчдад газарчлан хөтөч хийж буй орчуулагч нарын мэдлэг, тайлбарлах ур чадварыг дээшлүүлэх, япон жуулчидтай харилцах менежментийг сайжруулахад сургалтын зорилго оршино.

Сургалтын хөтөлбөр:

д/д	Сэдэв	Заах багш	Хугацаа
4-р сарын 5-ны Бямба гараг			
1	Нээлт	Э.Баттулга (Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга)	11:00 – 11:05
2	Япон жуулчдын онцлог, тэдний хүсдэг зүйл, асуудаг асуулт	Ч.Буянбадрах (Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв) урилгаар	11:05 – 13:30
3	Япон жуулчдыг угтах, зочид буудалд байрлуулах, хоолны газарт үйлчлүүлэх үеийн үг хэллэг, тайлбар хийхэд анхаарах зүйл (япон хэл дээр)	“Target consulting ХХК” –ийн багш Kishimoto Sayaka	13:30 – 15:30
4	Завсарлага (Цайны цаг)		15:30 – 15:45
5	Хотоос гадагш урт хугацааны аялалд гарах үеийн тайлбар, үг хэллэг, анхаарах зүйл (япон хэл дээр)	“Target consulting ХХК” –ийн багш Kishimoto Sayaka	15:45 – 16:45
6	Монголын Үндэсний Музейн тайлбар (япон хэл дээр)	“Target consulting ХХК” –ийн багш Kishimoto Sayaka	16:45 – 17:45
7	Ардын урлагийн тоглолт буюу уртын дуу, морин хуур, хөөмэй, баруун монгол ардын бүжиг, цам, бөөгийн бүжиг, уран нугаралт зэргийг тайлбарлах үг хэллэг (япон хэл дээр)	“Target consulting ХХК” –ийн багш Kishimoto Sayaka	17:45 – 18:45
4-р сарын 6-ны Ням гараг			
9	Эрдэнэзуу хийд, хийдийн үзмэр буюу буддын шашны соёлын өвийн тухай тайлбар (япон хэл дээр)	“Target consulting ХХК” –ийн багш Kishimoto Sayaka	09:00 – 10:30
10	Монгол махан хоол буюу хорхог,	“Target consulting ХХК” –	10:30 – 11:30

	цагаан идээний төрлүүд, айраг, хонь гаргах үйл ажиллагаа зэргийн тайлбар (япон хэл дээр)	ийн багш Kishimoto Sayaka	
11	Монгол үндэсний дээл хувцас, малгай, гутал, бүсний утга учир, хээ хуарын бэлгэдэл зэргийн тайлбар (япон хэл дээр)	“Target consulting ХХК” – ийн багш Kishimoto Sayaka	11:30 – 12:30
12	Монгол гэр сууц, бүрдэл хэсгүүдийн утга учир (япон хэл дээр)	“Target consulting ХХК” – ийн багш Kishimoto Sayaka	12:30 – 13:30
13	Цайны завсарлага		13:30 – 14.00
14	Монголын палеонтологийн олдвор, голлох олдвор ба үзмэрийн тухай (япон хэл дээр)	“Target consulting ХХК” – ийн багш Kishimoto Sayaka	14.00 – 16:00
15	Улаанбаатар хотын түүх, хотын аялал зохион байгуулахад анхаарах зүйлс	“Target consulting ХХК” – ийн багш Kishimoto Sayaka	16.00-18.00
16	Гэрчилгээ гардуулах		18:00 – 18:10

Хамрах хүрээ: Япон хэлний хөтөч-тайлбарлагч нар хамрагдана.

Зохион байгуулагч: Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Олон улсын аялал жуулчлалын хөгжлийн төв


Хугацаа: 2014 оны 4-р сарын 5, 6-ны Бямба, Ням гарагт зохион байгуулна.

Хүрэх үр дүн: Монголд зочлон аялж буй японы жуулчдад үйлчлэх хөтөч тайлбарлагч нарын мэдлэг, тайлбарлах ур чадварыг дээшлүүлэх, жуулчдад үзүүлэх үйлчилгээг сайжруулах, япон жуулчдын онцлогт тохирсон аяллыг удирдан зохион байгуулах, япон хэлтэй хөтөч нарын хэлний мэдлэг үгсийн санг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой.

Зохион байгуулах болон бүртгэх газар: Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дэргэдэх Аялал жуулчлалын мэдээлэл, сурталчилгааны төв (Бага тойруу-15 Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Нийслэлийн Засаг захиргааны 4-р байр хуучнаар Улаанбаатар банкны байрны Баруун хойд талын хаалга) Холбоо барих утас: 7012-8687, 99838674

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын
2014 оны 04 сарын 03-ний өдрийн
А/20 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



“ЯПОН ХЭЛНИЙ ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧДЫН
УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ”
СУРГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Багшийн төлбөр	17	15000	255000
2	Цай кофе	80	1000	80000
	Нийт дүн			335000

ТӨСӨВ ЗОХИОСОН:
НАЖГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

Ш. Ундармаа Ш.УНДАРМАА

ХЯНАСАН:
АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ

П. Ариунаа П.АРИУНАА

-ooOoo-